

К:36



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот


**Дэд хөтөлбөр, сангийн журам
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.4 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 11/41 тоот тогтоолын 3.3.68 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 1/4035 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, нийслэлийн иргэдэд стандартын шаардлага хангасан шинэ тээврийн хэрэгслээр үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, тэдгээрийг дэмжин ажиллах зорилгоор "Нийслэлийн нийтийн тээврийг 2020 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Нийслэлийн нийтийн тээврийг 2020 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр батлагдсантай холбогдуулан "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-г байгуулж, журмыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолоор батлагдсан журмын дагуу сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл /-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТТУЛГА





16.12.2013.

1110307415

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 22 дугаар сарын 15 өдрийн
15.1 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл, хэрэгцээ

Нийтийн тээврийн ажил үйлчилгээ нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил болон иргэд, зорчигчдын аж амьдралд ихээхэн нөлөө үзүүлж байдаг учраас энэ салбарын хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг оновчтой зөв тодорхойлж, шуурхай шийдвэрлэж байх нь бидний хойшлуулшгүй чухал зорилт юм.

Нийслэл хотын хүн ам жилд 4 хувиар өсч, авто тээврийн хэрэгсэл жилд 15 хувиар нэмэгдэж нийслэлийн хүн амын 60 гаруй хувь нь нийтийн тээврээр зорчиж байна. 2013 оны 3 улирлын байдлаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобус, троллейбусны 50 гаруй хувь нь 10 жилээс дээш настай болж ашиглалтын хугацаа нь дуусч байна.

Нийслэл хотын тээврийн үйлчилгээг шинэ шатанд гаргах, одоогийн тогтолцоонд зарчмын өөрчлөлт хийж сайжруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тээврийн ажил үйлчилгээтэй холбоотой олон талт ажлыг идэвх санаачлага гарган оновчтой зохион байгуулж үр дүнтэй ажиллахыг өнөөгийн хотын амьдрал зайлшгүй шаардаж байгаа тул "Нийслэлийн нийтийн тээврийг 2020 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр" гарган хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Нийслэлийн нийтийн тээврийг 2020 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөрийн зорилго нь салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, байгаль орчинд хор нөлөө багатай стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгсэл авч ашиглах, нийтийн тээврийн салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх замаар Улаанбаатар хотын иргэдийн тээврийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг хангасан аюулгүй, соёлтой, шуурхай тээврийн үйлчилгээний тогтвортой системийг бий болгоход оршино.

Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

3.1. Нийслэлийн нийтийн тээврийг 2020 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөрийн ерөнхий нөхцлийг дараах байдлаар тодорхойлов:

3.1.1. **Санхүүжилтийн эх үүсвэр:** "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-гийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Орон нутгийн төсвөөс санг үүсгэн байгуулахад зориулан олгосон санхүүгийн дэмжлэг;
- Гадаад улс орон, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, дэмжлэг хандив;
- Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийсэн аж ахуйн нэгж байгууллагуудаас эргэн төлөгдөх төлбөр;
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

3.1.2. **Хэрэгжүүлэх механизм:** Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, эргэн төлөгдөх нөхцлөөр нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтийг хийх,

3.1.3. **Хэрэгжүүлэх хугацаа:** 2020 он хүртэл,

3.1.4. **Эцсийн үр дүн:** Нийслэл хотын иргэдийн эрэлт хэрэгцээг хангасан аюулгүй, соёлтой шуурхай найдвартай нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох.

Дөрөв. Хэрэгжүүлэх байгууллага

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Өмчийн харилцааны газар, нийслэлийн Тээврийн газар, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд оролцоно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэлбэр

5.1. Нийслэл хотын нийтийн тээврийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд заасан чиглэл, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад дараах байгууллагууд оролцоно.

5.1.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх талаар гадаад улс орон болон олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах;

5.1.2. Нийслэлийн тээврийн газар дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобусны паркыг шинэчлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх шаардлагатай, тооцоо судалгааг гаргаж, хэрэгжүүлэх;

5.1.3. Нийслэлийн өмчийн харилцааны газар дараах чиг үүрэгт оролцоно:

- Хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх;

5.1.4. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

5.1.5. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагууд дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Хөтөлбөрийн хүрээнд эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

Зургаа. Дэд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

6.1. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобусны паркыг үе шаттайгаар шинэчлэх;

6.2. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд бүртгэл хяналтын /GPS/ систем, тээвэрлэлтийн цахим төлбөрийн систем зэрэг дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх замаар тээврийн үйлчилгээг зохицуулах "Цахим" тогтолцоог бий болгох;

6.3. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж төр, хувийн хэвшлийн үйлчилгээний чанар соёл, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

6.4. Нийтийн тээвэрт суурилсан хот байх үндсэн зарчмыг баримтлан дэвшилтэт техник технологи, программ хангамжийг ашиглан нийтийн тээврийн сүлжээний оновчтой төлөвлөлтийг боловсруулан, өндөр үр ашигтай тээврийн төрлийг түлхүү хөгжүүлэх;

6.5. Улаанбаатар хотод орчин үеийн багтаамж ихтэй тээврийн шинэ төрөл /Метро, Тусгай замын автобус "BRT"/ нэвтрүүлэх нарийвчилсан судалгаа хийх, ажлын зураг төсөв боловсруулах, бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх;

6.6. Нийслэл хотын гол гудамж, замын нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцыг үе шаттайгаар бууруулах;

6.7. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, орчин үеийн техник технологид суурилсан ухаалаг удирдлагын менежментийг бий болгох;

6.8. Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн харьцааг зохистой харьцаанд хадгалах;

6.9. Таксины үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, таксины тээврийн хэрэгслийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллах;

6.10. Нийтийн тээврийн үйлчилгээний автобус, троллейбус дотооддоо угсарч үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах;

6.11. Алслагдсан гэр хороолол, суурьшлын цэгүүдийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

6.12. Авто тээврийн байгууллагуудын мэргэжлийн үр чадварыг байнга дээшлүүлэх, өртөг зардлыг бууруулах;

6.13. Салбарын хөгжлийн шаардлагыг хангахуйц мэдлэг, чадвар, туршлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэх, авто тээврийн аюулгүй байдлыг хангахуйц жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх;

6.14. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд олон улсын стандартыг нэвтрүүлж, нутагшуулах;

6.15. Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифийг эдийн засгийн үр ашгийн зарчим, дотоодын нөхцөл байдалтай уялдуулан гадаад валютын ханш, шатахууны үнэ зэрэг бодит зардал дээр үндэслэн шинэчлэн тогтоон мөрдүүлж байх;

6.16. Тээвэрлэлтийн зайнаас хамаарсан төлбөрийн уян хатан системийг бий болгох;

6.17. Нийтийн тээврийн үйлчилгээний ашиг алдагдлыг тооцож, зөрүүг татаас хэлбэрээр төрөөс санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх;

6.18. Тээврийн ложистик тогтолцоог хөгжүүлэх замаар тээвэрлэлтийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх.

Долоо. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

7.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанар соёл болон аюулгүй, найдвартай байдал дээшилнэ;

7.2. Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарь, чиглэл маршрутын талаарх бодит мэдээллийг иргэд цаг алдалгүй авах боломж бүрдэнэ;

7.3. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр бүрдэнэ;

7.4. Иргэд нийтийн тээврээр зорчих сонирхол нэмэгдэж, улмаар замын хөдөлгөөний түгжрэл саатал багасна;

7.5. Авто тээврийн хэрэгслээс ялгарах агаарын бохирдлын хэмжээ буурна;

7.6. Тээвэрлэлтийн зайнаас хамаарсан хөлс төлөлтийн систем бий болсноор нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн тогтолцоо өөрчлөгдөнө.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын
13-ний өдрийн 14 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан нь (цаашид "Сан" гэх) Төсвийн тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон энэхүү журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.2. Сангийн үйл ажиллагааг явуулах, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Сангийн зорилго нь нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжин ажиллахад оршино.

1.4. Сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно.

1.5. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах, санхүүжилтийн байдал болон сангийн бусад үйл ажиллагаанд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналт тавьж, ажиллана.

Хоёр. САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Сангийн удирдах байгууллага нь Сангийн Зөвлөл байна. /цаашид "Зөвлөл" гэх/ Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Зөвлөлийн дарга байна.

2.3. Зөвлөлийн даргын санал болгосноор Зөвлөлийн нарийн бичгийн дарга болон гишүүдийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Нийслэлийн Тээврийн газрын холбогдох албан тушаалтнууд, болон тээврийн салбарт үйл ажиллагаа

явуулж байгаа төрийн бус байгууллага, иргэний төлөөллөөс бүрдсэн есөөс доошгүй гишүүнтэй байхаар 3 жилд нэг удаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас томилно.

2.4. Зөвлөлийн дарга нь сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.5. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэх ба Зөвлөлийн дарга, Зөвлөлийн гишүүдэд энэ журмын 4.7-д заасны дагуу сангийн үйл ажиллагааны явцыг тогтмол тайлагнана.

2.6. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхтэй байна.

2.6.1. Зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлах;

2.6.2. Сангийн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалт, явцын тайлантай танилцах, үнэлэлт дүгнэлт өгөх;

2.6.3. Сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох зардлыг хэлэлцэн батлах асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэр гаргах;

2.6.4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагуудыг сонгох асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэх;

2.6.5. Сангийн улирал, жилийн ажлын тайланг хэлэлцэх;

2.6.6. Сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох талаар холбогдох этгээдэд санал тавих;

2.6.7. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах Эд хөрөнгө эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ, Барьцааны гэрээ болон төсөл хөтөлбөр санхүүжүүлж хэрэгжүүлэхтэй холбогдох бусад гэрээний загвар, бичиг баримтын бүрдүүлбэрийг холбогдох хуульд нийцүүлэн Зөвлөлөөр хэлэлцэн батална.

2.7. Сангийн Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн нийт гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хуралдаан олонхийн саналаар шийдвэр гаргана. Хэрэв хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

2.8. Сангийн Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг сангийн орон тооны санхүүгийн ажилтан хөтөлж, гарах шийдвэрийг дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.9. Сангийн өдөр тутмын санхүүгийнүйл ажиллагааг зохион байгуулах, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар холбогдох байгууллагад тайлан мэдээ гаргах үүрэг бүхий орон тооны санхүүгийн ажилтантай байна.

2.10. Сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтан нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, журмын дагуу бүртгэж хөтөлнө.

2.11. Сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтан, түүний цалин хөлсний хэмжээ, Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээ болон бусад үйл ажиллагааны зардал, ажил үүргийн хуваарийг сангийн Зөвлөлийн Хурлаар хэлэлцүүлэн батална.

Гурав. САНГИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

3.1. "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан"—гийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

3.1.1. Орон нутгийн төсвөөс санг үүсгэн байгуулахад зориулан олгосон санхүүгийн дэмжлэг;

3.1.2. Гадаад улс орон, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, дэмжлэг хандив;

3.1.3. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлт хийсэн аж ахуйн нэгж байгууллагуудаас эргэн төлөгдөх төлбөр;

3.1.4. Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

3.2. Санг дараах зориулалтаар зарцуулна. Үүнд:

3.2.1. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр,

3.2.2. Нийтийн тээврийн парк шинэчлэлтэнд зориулсан эргэн төлөгдөх төлбөр;

3.2.2. Орон тооны санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтны цалин хөлс, Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн урамшууллын зардал, бичиг хэрэг, шуудан холбооны зардал болон сангийн үйл ажиллагаатай холбогдох бусад зардал.

Дөрөв. САНГААС ХӨРӨНГӨ ГАРГАХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

4.1. Сангийн хөрөнгийг нийслэлийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулна.

4.2. Сангийн хөрөнгөөс төсөл, хөтөлбөр болон эд хөрөнгө эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээг санхүүжүүлэх асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана.

4.3. Сангийн данснаас хөрөнгө гаргах нэгдүгээр гарын үсгийг Зөвлөлийн дарга, хоёрдугаар гарын үсгийг сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл хариуцсан ажилтан зурна.

4.4. Сангийн Зөвлөлөөс ирүүлсэн шийдвэр, бусад санхүүгийн баримт, материалыг үндэслэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс санхүүжилтийг олгоно. Санхүүжилтийг уг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн онцлогтой уялдуулан бүрэн болон хэсэгчлэн олгож болно.

4.5. Сангийн санхүүгийн эх үүсвэр, зарцуулалтын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор гаргаж сангийн Зөвлөлд тайлагнаж, жилийн тайланг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

4.7. Сангийн эх үүсвэр, зарцуулалтанд Аудит, мэргэжлийн хяналтын байгууллагаар жил бүр хяналт, шалгалт хийлгэнэ.

Тав. ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-гаас дараах нөхцөл шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад эд хөрөнгө эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ хийгдэнэ:

5.1.1. Нийтийн тээврийн салбарт 3-аас доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай;

5.1.2. Мэргэжлийн инженер техникийн багтай байх,

5.1.3. Санхүүгийн чадавхитай байх,

5.1.4. Нийтийн тээврийн үйлчилгээ явуулах стандартын шаардлага хангасан байх.

Зургаа. ХАРИУЦЛАГА

6.1. Сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар аудит, мэргэжлийн хяналтын болон хууль хяналтын байгууллагын дүгнэлтээр хууль бус үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон нөхцөлд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас Санг татан буулгаж болно.

6.2. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, журамд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

6.3. Энэ журмын 6.2-д заасныг зөрчсөн, эсхүл сангийн хөрөнгийг сангийн Зөвлөлийн шийдвэргүйгээр ашигласан, зарцуулсан, санхүүжилтийг өөр байгууллагад олгосон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж байгууллага нь эзэмшиж буй өмч, хөрөнгийнхөө эргэн төлөх төлбөрийг тогтоосон хугацаанд санд төлнө.

6.5. Санд төвлөрүүлэх хөрөнгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагуудад гэрээгээр тохиролцсон алданги тооцно.

6.6. Сангийн хөрөнгөөр бий болсон өмч хөрөнгийг эвдэж гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон тохиолдолд үлдэгдэл төлбөрийг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага бүрэн төлж барагдуулна.

6.7. Энэхүү журмын 2.6.7-д заасан гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой төсөл, хөтөлбөрийг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх эрхийг түр түтгэлзүүлэх хүртэл арга хэмжээг авна.

6.8. Аливаа маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлүүлэх бөгөөд хэрэв шийдвэрлэх боломжгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.9. Санг татан буулгасан тохиолдолд түүний өмч хөрөнгөтэй холбоотой болон бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

-----oOo-----